

МОНГОЛЫН БҮЖГИЙН СПОРТЫН ХОЛБОО

АНТИ-ДОПИНГИЙН КОД

1-р зүйл. Үндсэн зарчмууд

- I. Допинг нь Бүжгийн спорт ба анагаах ухааны ёс суртахууны үндсэн зарчмуудыг зөрчинө.
- II. Допингийг эрс хориглоно.
- III. Допингийн тодорхойлолтод багтсан аливаа бодисыг ашиглахыг санал болгох, зуучлах, зөвшөөрөх, хэрэглэхийг хялбарчлах, нуун далдлах, наймаалахыг мөн хориглоно.
- IV. Анти-допинг бол МБСХ-ны ДҮРЭМ-ийн 19-р зүйлийн 1, 2-д заагдсан субъектуудын нэг юм.
- V. МБСХ-ны гишүүн холбоод энэхүү дүрмийг өөрсдөө шууд шүүн таслах эрхтэйгээр мөрдүүлэх нь МБСХ-ны гишүүнчлэлийн нөхцлийн нэг хэсэг болно.
- VI. Энэхүү Анти-допингийн дүрэм нь МБСХ-ны ДҮРЭМ-ийн салшгүй чухал хэсэг юм.

2-р зүйл. Тодорхойлолтууд

- I. Ойлголтуудын тодорхойлолт
 1. “Допинг” гэж:
 - a) Тамирчны амжилтыг нэмэгдүүлэх боломжтой, тамирчны эрүүл мэндэд далдуур хор хөнөөл учруулах бодис эсвэл аргыг хэрэглэх,
 - b) Тамирчны бие махбодоос хориотой бодис илрэх эсвэл спортын амжилтаа нэмэгдүүлэх зорилгоор хориотой бодис, арга хэрэглэсэн нь нотлогдохыг хэлнэ.
 2. “Цусан дахь допинг” гэж тамирчны биеэс цус авах аргаар эсвэл тамирчин бэлтгэлийн үе шатандаа түүнээс цус авахыг зөвшөөрөөгүй бол өөр аргаар гаргаж авсан тамирчны цус, цусны улаан бөөм болон бусад цусан бүтээгдэхүүний судалгаа юм.
 3. “Санаатай допинг” гэж хэн нэгэн зориуд эсвэл эсрэгээр допинг хэрэглэх дүрэм болон нөхцлийг зөрчсөн нь нотлогдох эсвэл тэгж бодогдох бүх нөхцөл бүрдсэн нөхцөл дэх допингийг хэлнэ.
 4. “Далдлах агент” гэж тамирчны биеэс авсан шээсний болон бусад шинжилгээний үр дүнг багасгах эсвэл өөрчлөх зорилгоор ашигласан бодис болон аргыг хэлнэ.
 5. “Оролцогч” гэж МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн тэмцээнүүд болон МБСХ-ны гишүүдийн шууд ба дам удирдлагаар зохион байгуулагдаж байгаа тэмцээнүүдэд оролцох буюу бэлтгэж байгаа тамирчид эсвэл тэдэнд үйлчилж байгаа аливаа тамирчин, багш, дасгалжуулагч, түүнчлэн холбооны албаны хүн, эмнэлгийн ажилтныг хэлнэ.
 6. “Фармаколог (эм зүй), хими, физикийн аргууд” гэж допингийн шинжилгээ хийх зорилгоор хүний биеэс авах шээс болон бусад шингэнд хийсэн шинжилгээний үр дүнг өөрчлөх чадвартай далдлах агентуудыг багтаасан дурын бодис, аргуудыг хэлнэ. Үүнд: эпитестостерон болон бромантан хэрэглэх, пробеницид ба түүний хувилбаруудын тусламжтайгаар тестостерон болон эпитестостероны үр дүнг өөрчилж бөөрний үйл ажиллагааг тоормослох зэрэг багтана.
 7. “Хориотой аргууд” – энэхүү дүрмээр тодорхойлогдсон аливаа арга.
 8. “Хориотой бэлдмэл” - энэхүү дүрмээр тодорхойлогдсон аливаа бэлдмэл.
 9. “Адил төсөөтэй бэлдмэл” – энэхүү дүрэмд заагдсан хориотой бэлдмэлүүд болон бусад бэлдмэлүүдтэй эм зүйн үйлчлэл, химийн бүтцээрээ адил бэлдмэлүүд.
 10. “Дэлгэрүүлэх” – аливаа хүн эрх бүхий газраас зөвшөөрөл авалгүйгээр хийсэн дараах үйлдэл:
 - A. Хориотой бэлдмэлүүдийг ямар нэг аргаар үйлдвэрлэх, гаргах, боловсруулах, бэлтгэх, хадгалах, импортлох, экспортлох, тээвэрлэх, төлбөртэй болон төлбөргүйгээр санал

болгох, түгээх, худалдах, хэлэлцээр хийх, солилцох, дурын хэлбэрээр авах, захиалах, худалдаа наймаа эрхлэх, дамжуулах, хүлээн авах, эзэмших, хадгалах, худалдан авах, олж авах.

В. 2.10-д заагдсан зүйлст шууд ба дам аргаар санхүүжүүлэх, санхүүжүүлэхэд зуучлах, дээрх бэлдмэлүүдийг хэрэглэх, хэрэглэхэд тус болох.

С. Хориотой аргуудыг хэрэглэх.

11. “Хэрэглэх” – хориотой бодисуудыг тарилга эсвэл бусад дурын аргаар хэрэглэх эсвэл хориотой аргуудаас хэрэглэх, хэрэглэх зөвөлгөө өгөх, хэрэглэхийг зөвшөөрөх эсвэл хайцаалах.

12. “Гишүүн” – МБСХ-ны гишүүн байгууллага.

13. “МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгч” – МБСХ-ны Тэргүүлэгчдээс тухайн албыг гүйцэтгэхээр томилогдсон МБСХ-ны Тэргүүлэгч гишүүн.

14. “Зохион байгуулагч” – МБСХ-ны тэмцээний дүрэмд заагдсан Бүжгийн спортын тэмцээнүүдийг зохион байгуулах эрхийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс олж аван зохион байгуулахаар томилогдсон аливаа байгууллага, хувь хүн.

II. Хориотой бодис болон хориотой аргуудын жагсаалт

ОУОХ-ны жагсаалт эсвэл ОУОХ-ноос үе үе гаргадаг хориотой бодис болон аргуудын жагсаалт нь энэхүү Дүрмийн үндсэн хэсэг болно. Энэхүү жагсаалтыг МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгч байнга үзэж танилцаж байх ёстой бөгөөд түүнийг өөрчлөх, залруулах саналыг тавина. Нэмэлт, өөрчлөлтийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс батлах бөгөөд баталснаас хойш 3 сарын дотор хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлтийг Анти-допингийн дүрмийн 6-р зүйл, нэмэлт журмын “А” хавсралтад тусгах ёстой.

3-р зүйл. Хэрэглэгдэх хүрээ

I. Хэрэглээ

1. Энэхүү дүрмийг тэмцээний бүх оролцогчид мөрдөнө.

2. Гишүүд нь МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн аливаа тэмцээнд оролцуулахаар нэр дэвшүүлсэн бүжигчид (тамирчид), дасгалжуулагчиддаа энэхүү Анти-допингийн дүрмийн зүйл заалт бүрийг танилцуулсан байх ёстой.

3. Бүжгийн спортын тэмцээнд оролцогчид энэхүү Анти-допингийн дүрмийг дагахаа хүлээн зөвшөөрч, дүрмийн “В” хавсралтад өгөгдсөн маягтыг бөглөнө. Гарын үсгээр баталгаажсан маягт нь тэмцээний зохион байгуулагч эсвэл оролцохоор нэрээ дэвшүүлсэн Гишүүдэд хүргэгдэнэ.

4. МБСХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн тэмцээн бүр дээр хүссэн хүн бүрд Анти-допингийн дүрэм болон Тэмцээний дүрмийг тарааж өгнө.

5. Тамирчин бүр допингийн шалгалтын субъект болох ёстой (шээсний шинжилгээ, цусны шинжилгээ болон хориотой бодис, арга хэрэглэснийг нотлох бусад арга техник).

6. Тэмцээний бусад оролцогчид нь энэхүү дүрмийн болзлыг дагах үүрэгтэй хэдий ч энэ дүрмийн нөхцөл ёсоор аливаа тамирчин хүн хориотой бодисууд болон аргуудыг хэрэглэхгүй байхыг зөвшөөрөхгүй байх баталгаа өгөх үүрэгтэй.

7. МБСХ-ны тэмцээнүүдэд нэр нь дэвшигдсэн тамирчид тэмцээний хүрээнд хийгдэж байгаа допингийн шинжилгээнд хамрагдахаас татгалзвал уг тамирчинг тэмцээнд оролцуулж болохгүй.

8. Гишүүд өөрсдийн хийсэн допингийн шалгалтын эерэг дүн бүрийг МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй.

II. Допингийн шалгалтанд орох үүрэг

1. МБСХ нь Анти-допингийн төлөөлөгчийн шийдвэрээр допингийн шинжилгээ явуулах үүргийг нь тухайн тэмцээнийг явуулж байгаа Гишүүдэд болон тэмцээнийг ивээн тэтгэгчдэд шилжүүлж болно. Хэрэв Анти-допингийн төлөөлөгч тухайн Гишүүд болоод ивээн тэтгэгчдийг допингийн шинжилгээ явуулах үүргээ шаардлагатай хэмжээнд биелүүлж чадахгүй гэж үзвэл Анти-допингийн төлөөлөгч өөр арга хэмжээ авч болно. Анти-допингийн төлөөлөгч эсвэл түүний эзгүйд түүний төлөөлөгч ямар төрлийн допингийн шинжилгээ (шээсний шинжилгээ, цусны шинжилгээ эсвэл аль алиныг нь) явуулахыг шийдвэрлэнэ.
2. МБСХ-ны гишүүнчлэлийн нэг нөхцөл бол аливаа Гишүүн холбоо, клуб бүр өөрийн дүрэм, дотоод журам, тэмцээний дүрэмдээ дараах зүйлсийг багтаах явдал юм.
 - а) Тухайн Гишүүн тэмцээний гадна допингийн шинжилгээ явуулж үр дүнг нь МБСХ-д жил бүр мэдээлэх үүрэгтэй.
 - б) МБСХ-ны зөвшөөрсөн нөхцлөөр Гишүүд өөрсдийн тэмцээнүүдэд допингийн шинжилгээ явуулна.
 - в) МБСХ-ны зөвшөөрсөн нөхцлөөр өөрсдийн тамирчиддаа тэмцээний гаднах шинжилгээ хийнэ.
 - д) Аливаа Гишүүн эсвэл түүний албаны хүн МБСХ болон Гишүүдэд допингийн шалгалт явуулахад нь туслах үүрэгтэй. Энэхүү шинжилгээг явуулахад саад хийх, хойшлуулах, заналхийлэх, саатуулах болон бусад аргаар саад хийх нь МБСХ-ны ДҮРЭМ-ийг зөрчсөн явдал болно.
3. МБСХ-ны Ур чадварын чансааны жагсаалтад бичигдсэн тамирчдын тэмцээний гаднах шинжилгээг МБСХ гүйцэтгэнэ. Бусад тамирчдын тэмцээний гаднах шинжилгээг Гишүүд өөрсдөө хийнэ.
4. Энэхүү дүрэм болон түүний санааг бүрэн төгс биелүүлэхийн тулд допингийн шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай дараах факторуудыг харгалзан үзнэ:
 - а) Гишүүн бүр өөрсдийн хийсэн допингийн шинжилгээний эерэг хариу бүрийг МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгчид мэдэгдэнэ. Эдгээр хариуг МБСХ-ны бүх Гишүүдийн нэрийн өмнөөс үүрэг хүлээсэн МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгч авч үзнэ. Тухайн Гишүүдийн явуулсан допингийн шинжилгээний эерэг хариуг бүх Гишүүд заавал хүлээн зөвшөөрнө.
 - б) МБСХ өөрөө допингийн шинжилгээг явуулах тохиолдолд Гишүүн бүр тэрхүү допингийн шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх ба энэхүү шийдвэрийг биелүүлэх арга хэмжээг хүлээн авна.
 - в) Хэрвээ сорьц авах арга нь тамирчны аюулгүй байдалд баталгаа өгсөн, шинжилгээ хийх дүрэм нь Анти-допингийн төлөөлөгчийн санаанд нийцсэн бол тэрээр МБСХ-ны бүх Гишүүдийн нэрийн өмнөөс МБСХ-ноос бусад спортын байгууллага эсвэл тухайн байгууллагын гишүүдийн явуулсан допингийн шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрч болно.
 - д) МБСХ-ноос өөр дүрэм журмаар МБСХ-ноос бусад спортын байгууллага, түүний гишүүдийн явуулсан допингийн шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрөхийг санал болгосон тохиолдолд тухайн тамирчин мэдэгдлийг бичгээр авах ёстой. Хэрвээ тамирчин зөвшөөрлийг бичгээр үйлдэхийг хүсвэл мэдэгдэл өгснөөс хойш сарын дотор Анти-допингийн төлөөлөгчид өгнө.
 - е) Анти-допингийн төлөөлөгч МБСХ-ноос өөр спортын байгууллагын явуулсан допингийн шинжилгээний эерэг үр дүнг хүлээн зөвшөөрөхөөр шийдсэн тохиолдолд тухайн тамирчныг МБСХ-ны холбогдох дүрмийг зөрчсөн, буруутай гэж үзэж энэхүү Дүрэмд заагдсан арга хэмжээ, шийтгэлийг оногдуулна. Бүх Гишүүд энэхүү шийдвэрийг биелүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

4-р зүйл. Допингийн шинжилгээний хэрэгжилт

- I. Шинжилгээ хийх тамирчдын хэсгийг сонгож авах

Допингийн шинжилгээг дараах тохиолдолд авна:

1. Хосын тэмцээнд финал, хагас финал, дөрөвний нэг финалд шалгарсан хүйс бүрээс гурав, нийт зургаан тамирчинг, тэдний хоёр нь түрүүлсэн тамирчин байх ба бусдыг нь шодож сонгоно.
2. Багийн тэмцээнд финал, хагас финалд шалгарсан хүйс бүрээс гурав, нийт зургаан тамирчинг, тэдний хоёрыг түрүүлсэн багаас сонгох ба дөрвийг нь шодож сонгоно.
3. МБСХ-ноос Анти-допингийн дүрмийг зөрчсөн гэх үндэслэлээр сэжиглэгдсэн тамирчдад.

II. Шинжилгээг зөвшөөрөх, мэдээллийг зарлах үүрэг

1. Допингийн шинжилгээний хэсгийн ахлагч аливаа тамирчинг шинжилгээнд орох (4-р зүйлийн 6.1) тухай мэдэгдэл авахаасаа өмнө эсвэл дараа нь допингийн шинжилгээ болон допингийн шинжилгээний хэсгийн хяналтаас зугтасан, зугсахыг оролдсон гэж үзвэл тамирчинг 5-р зүйлийн 7-г зөрчсөн гэж үзэж заагдсан шийтгэлийг оногдуулна.
2. Тамирчид шаардлагатай хэмжээгээр хэдэн удаа ч допингийн шинжилгээ явуулахад саад хийхгүй байх ёстой бөгөөд допингийн шинжилгээ явуулах хүртэлх сүүлийн гурван хоногт хэрэглэсэн эмийн тухай мэдээллээ өгч шинжилгээ явуулахад идэвхитэй оролцох ёстой.

III. Допингийн шинжилгээний хэсгийг томилох

1. Тэмцээний зохион байгуулагч нь тухайн тэмцээн дээр допингийн шинжилгээ явуулах Допингийн шинжилгээний хэсгийг сонгох ёстой.
2. Допингийн шинжилгээний хэсэг нь дор хаяж хоёр (нэг нь ахлагч, нөгөө нь туслагч) хүнээс бүрдэнэ. Шинжилгээнд хамрагдах тамирчдын хүйсийг допингийн шинжилгээний хэсгийн саналаар сонгоно. Допингийн шинжилгээний хэсгийн дор хаяж нэг гишүүн нь тамирчидтай ижил хүйсийнх байна. Допингийн шинжилгээний хэсгийг ахлагч нь эмч байна.

IV. Допингийн шинжилгээг тухайн байрлалд явуулах

Допингийн шинжилгээний хэсэг нь тэмцээн дээр урьдчилан мэдэгдэлгүйгээр ирэх бөгөөд тэмцээний зохион байгуулагч болон албаны хүмүүст ирснээ мэдэгдэнэ. Дараа нь нэн даруй допингийн шинжилгээний хэсгийг допингийн шинжилгээ явуулах өрөөнд оруулж, хэрвээ шаардлагатай бол тухайн допингийн шинжилгээ нь дүрмийн дагуу, гомдол гаргалгүйгээр явагдах баталгааг гаргаж өгнө.

V. Шинжилгээнд хамрагдах тамирчдыг шодож сонгох

Хэрэв шаардлагатай бол допингийн шинжилгээний хэсгийн дарга 4-р зүйлд заагдсаны дагуу тамирчдыг шодож сонгоно.

VI. Тамирчдын мэдэгдэл

1. Тэмцээний гадна допингийн шинжилгээ явуулах бол тамирчинд допингийн шинжилгээний тухай сануулах бөгөөд тэд тэмцээний эхэн гэхэд допингийн шинжилгээнд ороход бэлэн болсон байх үүрэгтэй.
2. Шодогдож сонгогдсон тамирчид тэмцээн дууссаны дараа эсвэл финалын дүнг зарласны дараа допингийн шинжилгээ явуулах өрөөнд нэн даруй очих ёстой.
3. Тамирчин допингийн шинжилгээнд орохдоо өөрийн сонгосон хүнээ авч очих эрхтэй (албаны хүн, дасгалжуулагч, эмч, массажчин г.м).
4. Зарчмын дагуу допингийн шинжилгээг тэмцээн дууссанаас хойш нэн даруй авна.

VII. Шээсний шинжилгээний журам

1. Допингийн шинжилгээний өрөөнд тамирчныг дагалдаж зөвхөн дараах хүмүүс орж ирнэ:
 - a) Зохион байгуулагчдын төлөөлөгч
 - b) Допингийн шинжилгээний хэсгийн гишүүд
2. Допингийн шинжилгээний өрөөнд ирэхдээ тамирчин өөрийн бичиг баримтаа авч ирнэ (паспорт, жолооны үнэмлэх, хувийн хэрэг г.м).
3. Допингийн шинжилгээний өрөөнд хүрч очсон хугацаа болон тамирчны хувийн мэдээллийг допингийн шинжилгээний хэсгийн холбогдох бичиг баримтанд тэмдэглэнэ.
4. Тамирчин өөрөө шээсний шинжилгээний саваа авч очно (стакан). Допингийн шинжилгээний хэсгийн ижил хүйстэй гишүүний ажиглалтан дор саванд 75 мл-ээс багагүй шээсээ өгөх ёстой. Дараа нь тамирчин тусгай кодтой хоёр контейнер сонгон авна. Хоёр шилэн саван дээр тусгай код болон “А” ба “В” гэсэн үсэг сийлсэн байна. Тамирчин өөрөө авсан шээсээ хоёр жижиг шилэнд хийнэ (“А” савны гуравны хоёрыг, “В” савны гуравны нэгийг дүүргэнэ). Дараа нь савнуудыг таглана. Шилнүүдийг сайн тагласан эсэхийг шалгана. Тэгээд шилнүүдийг контейнерт байрлуулна. Контейнерүүдийг тусгай лацаар лацдана.
5. Шээсийг авах, кодын дугаарыг авах үед протокол хөтөлнө. Мөн протоколд допингийн шинжилгээ хүртэлх 72 цагийн дотор тамирчны хэрэглэсэн(тамирчны амаар мэдэгдсэн) бүх бэлдмэлүүд бичигдэнэ.
6. Тамирчин контейнер болон өгөгдлүүдийг шалгасны дараа протоколд гарын үсэг зурж допингийн шинжилгээ үнэн зөв явагдсаныг баталгаажуулна. Дараа нь протоколд допингийн шинжилгээний хэсгийн ахлагч, тамирчныг дагалдаж яваа хүн мөн Анти-допингийн төлөөлөгч (хэрэв байгаа бол) гарын үсэг зурна.
7. Тамирчин протоколын нэг хувийг авч үлдэнэ.
8. Допингийн шинжилгээ дууссаны дараа протокол болон контейнерыг савлан лацдаж, нэн даруй тэмцээний зохион байгуулагчид гардуулна. Зохион байгуулагч шээсний шинжилгээг холбогдох лаборатор руу явуулна.
9. Тамирчин нэг эсвэл хэд хэдэн оролдлогоор шаардлагатай хэмжээний шээсийг өгч чадахгүй бол гарсэн шээс нь тамирчны авч ирсэн шилэнд хадгалагдана. Дахин шээс гарах үед тамирчин өөрөө савыг онгойлгож хуучин болон шинэ шээсийг холино. Шээсийг дээр бичсэний дагуу хоёр шилэнд хуваана. Бусад нь дээр дурьдсаны ижил явагдана.

VIII. Цусны шинжилгээний журам

1. Цусны шинжилгээг зөвхөн эмнэлгийн мэргэшсэн ажилтан авна. Анти-допингийн цусны шинжилгээг явуулж байгаа аливаа албаны хүн тамирчныг цусны шинжилгээ авч дуустал эмнэлгийн хяналтанд байлгана.
2. Тамирчинд журмыг танилцуулж, түүнийг цусны шинжилгээ өгөхийг зөвшөөрсөн хуудсан дээр гарын үсэг зураагүй тохиолдолд ямар ч цусны шинжилгээг авахгүй. Хэрвээ тамирчин цусны шинжилгээ авахыг зөвшөөрөөгүй бол түүнээс шинжилгээ авахгүй ба доор дурьдсанаас бусад тохиолдолд допингийн шинжилгээнээс татгалзсаныг зөвшөөрөлгүй татгалзсан гэж үзнэ.
3. Цусны шинжилгээ авахад шаардлагатай дараах тоноглол нь шинжилгээ бүр дээр хангалттай хэмжээгээр байх ёстой. a) ба f) зүйл нь эмнэлгийн зориулалтаар цус авахад зориулагдсан байх ёстой. a) ба f) зүйл нь бэлэн болоод ариутгагдсан байх ёстой. Зүйлс:
 - a) Эмнэлгийн зүү (венийн canulae)
 - b) Вакуумын савалгаатай шприц
 - c) Пластик тариур
 - d) Зөөвөрлөх сав (вакуумны шприцэнд зориулагдсан)
 - e) Ариутгасан салфетк

f) Цус тогтоох боолт (тунникет)

Шинжилгээ бүр дээр хувьд ашиглагдах а) ба d) зүйл нь угсраан дотор байх ёстой.

4. Тамирчин цусны шинжилгээний угсрааг дор хаяж хоёр төрлөөс сонгох ёстой. Угсрааг сонгосны дараа шинжилгээ эхэлнэ. Цусны шинжилгээг явуулж байгаа албаны хүн тамирчны гарт цус тогтоох боолтыг тавихыг санал болгох ёстой. Гарнаас өөр биеийн бусад хэсгээс цус авахыг хориглоно. Допингийн шинжилгээний хэсгийн ахлагч тамирчны арьсыг тусгай салфеткаар арчиж ариутгаад венийн судаснаас цус авна. Допингийн шинжилгээний ахлагч өвчинг аль болох бага мэдрүүлэхийг хичээх хэрэгтэй. Допингийн шинжилгээний үед тамирчнаас дөрвөн гуурс цус авах шаардлагатай.

5. Дараах тохиолдолд тамирчин цусаа өгөхөөс татгалзах эрхтэй:

а) Цусны шинжилгээ авах хүн эмнэлгийн мэргэжлийн гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдолд;

б) Цус авах угсраан дахь а) ба d) зүйл нь ариутгагдаагүй эсвэл тэдгээрийн уут бүтэн биш;

в) Албаны хүн тамирчнаас 25 мл-ээс илүү хэмжээний цус авахыг санал болгох эсвэл оролдох.

6. Тамирчнаас дөрвөн вакуумын гуурс цус авах шаардлагатай. Эдгээр гуурсыг А ба В шинжилгээг зөөвөрлөх саванд байрлуулж, зөөвөрлөх савнуудыг нэн даруй лацдана. Шинжилгээний гуурс бүрд кодын дугаарыг тэмдэглэнэ. Холбогдох албаны хүн эдгээр кодын дугаарыг тухайн тамирчны допингийн шинжилгээний хуудсан дээр тэмдэглэнэ. Тамирчин шинжилгээний гуурсан дээрх код нь албаны хуудсан дээрхтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

7. Шинжилгээ өгсөн тамирчин, түүнийг дагалдан яваа хүн, Анти-допингийн төлөөлөгч болон допингийн шинжилгээний хэсгийн дарга допингийн шинжилгээний хуудсан дээр гарын үсэг зурж шинжилгээ үнэн зөв явагдсаныг баталгаажуулна. Хэрэв тамирчин эсвэл бусад хүмүүс шинжилгээ шаардлага хангаагүй гэж үзвэл энэ тухайх мэдэгдэл болон үндэслэлээ допингийн шинжилгээний хуудсан дээр бичнэ. Хэрвээ ийм мэдэгдэл байхгүй бол тамирчныг энэхүү журам зөрчихөөс татгалзсан гэж үзнэ.

8. Тамирчин мөн допингийн шинжилгээний хуудсан дээр хэрэглэсэн эм бэлдмэлүүдийнхээ жагсаалт, түүнчлэн урьдах зургаан сард цусны шинжилгээ хийлгэж байсан эсэхээ бичнэ.

9. Протокол болон савыг баглан лацдах ба Допингийн шинжилгээний комиссоос зохион байгуулагчид нэн даруй гардуулна. Дараа нь зохион байгуулагч холбогдох лаборатор руу явуулна.

IX. Шинжилгээг хадгалах ба илгээх

1. Эмнэлгийн мэргэжлийн хүмүүсийн мэдэлд шилжинэ.

2. Илгээхийн өмнө тухайн шинжилгээний тоо хэмжээ нь баримтан дээрх тоотой тохирч байгаа эсэхийг шалгана. Боломжийн хэрээр хөргөх эсвэл хөлдөөх хэрэгтэй.

3. Үндсэн “А” ба нөөц “В” шинжилгээнүүдыг лацадсан байх ёстой бөгөөд лабораторт аль болох хурдан хүргэнэ.

4. Тээвэрлэж байх үед савнуудыг нээж болохгүй. Хэрвээ шаардлагатай бол МБСХ гаалийн зорилгоор магадласан хаяг хадна. Гаднах савыг нээх нь допингийн шинжилгээг хүчингүй болгохгүй.

5. Тамирчнаас допингийн шинжилгээний зорилгоор авсан шинжилгээ нь МБСХ-ны өмч болно.

X. Допингийн шинжилгээнд орохоос татгалзсанаас үүдэх журам

Хэрвээ тамирчин шинжилгээнд шээс эсвэл цусаа өгөхөөс татгалзвал түүнд гарах үр дагавруудыг танилцуулна. Допингийн шинжилгээнээс татгалзвал 5-р зүйлийн 7-д зааснаар

арга хэмжээ авна. Хэрвээ тамирчин үргэлжлүүлэн татгалзсаар байвал энэхүү байдлыг протоколд тэмдэглэнэ. Энэ тэмдэглэлд МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгч (хэрвээ байвал) болон Допингийн шинжилгээний комиссын ахлагч гарын үсэг зурна. Протоколыг нэн даруй МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгчид гардуулна.

XI. Шинжилгээг шинжлэх

Шээс болон цусны шинжилгээг МҮОХ, ОУОХ-ны итгэмжлэгдсэн лабораторт шинжилнэ. Шинжилгээг лабораторт ирсний дараа боломжийн хирээр түргэн явуулна. Шинжилгээг мэдэх аргачлалаар явуулна. Шинжилгээний үр дүнг бичгээр үйлдэнэ.

XII. Тамирчинд шинжилгээний үр дүнг мэдээлэх

1. Лаборатор нь зохион байгуулагчид шинжилгээний үр дүнг бичгээр мэдэгдэж харин зохион байгуулагч үр дүнг цааш нь мэдэгдэнэ.

а) “Сөрөг” хариу гарсан тохиолдолд тамирчинд мэдэгдэнэ.

б) “Эерэг” хариу гарвал тамирчинд мэдэгдэхдээ түүнийг дараагийн шатны арга хэмжээ авахыг хүсч болохыг танилцуулж, шаардана. Мөн МБСХ-ны Анти-допингийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

2. Хэрвээ тамирчин “В” саван дахь шинжилгээг шинжлүүлэхийг хүсвэл зохион байгуулагч шинжилгээг зохион байгуулна. Тамирчин шинжилгээний үед биеэр байлцах эсвэл тодорхойлсон хүнээ байлцуулах эрхтэй. Эерэг хариу гарсан тохиолдолд давтан шинжилгээний зардлыг тамирчин өөрөө хариуцна.

3. Тамирчинд шинжилгээг “шүүх” боломж олгоно. “В” шинжилгээний хариу эцсийнх болно. Дараагийн шинжилгээг хийхийг зөвшөөрөхгүй.

XIII. Үнэ өртөг

МБСХ нь шинжилгээ авсан болон шинжилсэн зардлыг даана. 6-р зүйлийн 1-д заагдсан шийтгэл оноох үед тамирчин шинжилгээ авсан болон шинжилсэн зардлыг хариуцна.

5-р зүйл. Торгууль шийтгэл

I. Зарчмууд

Тамирчин хүний бие организмийн эд эс болон шингэнд энэхүү Анти-допингийн дүрэмд заагдсан нэг ч бодис байх ёсгүй. Хориг нь тамирчны хувийн хариуцлагаас хамаарч тавигдах ёстой.

II. Нотолгооны дүрэм

1. Шээс болон цусны шинжилгээний эерэг хариу нь тамирчны допинг хэрэглэсэн буруутайг нотлох анхдагч баталгаа болно.

2. Метаболикийн ба/эсвэл изотопийн радио хэмжилтийн аргаар гаргасан баталгаа нь анаболикийн андрогенийн стероидуудыг хэрэглэснийг нотлох эцсийн шийдвэр гаргахад хэрэглэгдэж болно.

3. Хориотой бэлдмэлүүд болон хориотой аргуудыг амжилттай болон амжилтгүй хэрэглэсэн нь хамаагүй. Хориотой бэлдмэлүүд болон хориотой аргуудыг хэрэглэсэн эсвэл допинг хэрэглэхийг оролдсон нь буруутайг нотлоход хангалттай.

III. Торгууль шийтгэл допинг хэрэглэсэн нөхцөлд

1. Анх удаа хэрэглэсэн нөхцөлд дараах шийтгэлийг оногдуулна:
 - a) Хэрвээ эфедрин, фенилпропаноламин, псевдоэфедрин, кофеин, стрихнин эсвэл эдгээртэй төсөөтэй бодисууд зэрэг хориотой бэлдмэлийг хэрэглэсэн бол:
 - aa) Бичгээр анхааруулга
 - ab) Аливаа зэрэглэлийн нэг болон хэд хэдэн тэмцээнд оролцох эрхийг нь хасах
 - ac) 20000CHF-ийн торгууль
 - ad) Аливаа тэмцээнд оролцох эрхийг нь 1-ээс 6 сараар хасах
 - b) Хэрэв дээрх а хэсэгт заагдаагүй хориотой бэлдмэлүүдийг хэрэглэсэн тохиолдолд:
 - ba) Аливаа зэрэглэлийн нэг болон хэд хэдэн тэмцээнд оролцох эрхийг нь хасах
 - bb) 20000CHF-ийн торгууль
 - bc) Аливаа тэмцээнд оролцох эрхийг доод тал нь 2 жилээр хасах.
2. Дараах тохиолдолд:
 - a) Санаатай допинг
 - b) Далдлах агент
 - c) Энэхүү дүрэмд дурьдсан шинжилгээг булзааруулах ба өөрчлөх зорилготой заль мэх
 - d) Эмнэлэг, эм зүй болон бусад мэргэжлийн хүмүүсийн допинг хэрэглэхэд хамтран оролцох

Дараах арга хэмжээ авна:

 - a) Хэрвээ эфедрин, фенилпропаноламин, псевдоэфедрин, кофеин, стрихнин болон бусад төсөөтэй хориотой бодисууд хэрэглэсэн бол
 - aa) Аливаа зэрэглэлийн нэг болон хэд хэдэн тэмцээнд оролцох эрхийг нь хасах
 - ab) 20000CHF-ийн торгууль
 - ac) Аливаа тэмцээнд оролцох эрхийг 2-оос 8 жилээр хасах.
 - b) Жагсаалтад орсон хориотой бэлдмэлүүдийг давтан хэрэглэсэн (давтан хэрэглэх гэсэн ойлголтонд допинг хэрэглэсэнээс хойш арван жилийн хугацаанд дахин хэрэглэх тохиолдол) тохиолдолд:
 - aa) Аливаа зэрэглэлийн спортын арга хэмжээнд оролцох эрхийг бүх насаар нь хасах
 - ab) 20000CHF-ийн торгууль
 - ac) Бүх арга хэмжээнд оролцох эрхийг 4 жилээс бүх насаар нь хасах.

IV. Тэмцээнээс гаргах

МБСХ-ны Антидопингийн төлөөлөгч шээс (“А” шинжилгээ) болон цусны шинжилгээний эерэг үр дүнгийн талаар мэдээлсэн тэр мөчөөс тамирчныг тэмцээнээс хасна.

V. Гүйцэтгэх эрхийг хасах

Тэмцээний үед допинг хэрэглэсэн аливаа тохиолдол нь авч болох бусад арга хэмжээг тооцолгүйгээр түүний олж авсан аливаа амжилтыг автоматаар хүчингүй болгоно (аливаа медаль, шагнал зэргийг хураана). Энэ тохиолдол нь энэ зүйлийн 3-рт заагдсан.

Хэрвээ тамирчныг баг ба формешн-хамтлагт гүйцэтгэх эрхийг хасвал энэ нь тухайн баг, хамтлагт ч хамаатай.

VI. Үр дүн

Тэмцээнд оролцогчийг допинг хэрэглэсэн гэж шийтгэх нь, *mutatis mutandis* эерэг үр дүн гарсан тэр үеэс хүчин төгөлдөр болно.

VII. Шинжилгээ өгөхөөс татгалзах

Допингийн шинжилгээ өгөх буюу шээс болон/эсвэл цусны шинжилгээ өгөхөөс татгалзах нь тамирчны үүргээ зөрчиж байгаа хэрэг мөн.

Тамирчин хүн МБСХ-ны Анти-допингийн дүрэмд заагдсан журам, баталгаа зөрчигдсөн тохиолдолд шээс ба цусны шинжилгээ өгөхөөс татгалзах эрхтэй.

1. Хэрвээ шинжилгээ өгөхөөс анх удаа татгалзаж байгаа бол дараах арга хэмжээг авна:
 - a) Урьдчилан сануулга
 - b) 20000CHF-ийн торгууль
 - c) Тэмцээнд оролцох эрхийг 1-ээс 6 сараар хасах
2. Хэрвээ шинжилгээ өгөхөөс хоёр дахь удаагаа татгалзаж байгаа бол дараах арга хэмжээг авна:
 - a) Аливаа зэрэглэлийн нэг болон хэд хэдэн тэмцээнд оролцох эрхийг нь хасах
 - b) 20000CHF-ийн торгууль
 - c) Аливаа тэмцээнд оролцох эрхийг 2-оос 8 жилээр хасах
3. Хэрвээ шинжилгээ өгөхөөс давтан татгалзаж байгаа бол дараах арга хэмжээг авна:
 - a) Аливаа зэрэглэлийн тэмцээнд оролцох эрхийг бүх насаар нь хасах
 - b) 20000CHF-ийн торгууль
 - c) Бүх тэмцээнд оролцох эрхийг 4 жилээс бүх насаар нь хасах.

VIII. Хориотой бэлдмэл түгээх, зөөх

Хориотой бэлдмэлийг хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болоод худалдааны байгууллагаар дамжуулан түгээхээс бусад аргаар түгээвэл дараах арга хэмжээг авна:

1. Спортын аливаа арга хэмжээнд оролцох эрхийг насаар нь хасна. Энэхүү арга хэмжээн дээр нэмээд аливаа хуулийн эрх мэдэл бүхий зохих шатны байгууллагаар шийтгэгдэнэ. Түгээхийг оролдсон аливаа оролдлогыг түгээсэнтэй адил тооцож шийтгэл хүлээлгэнэ.
2. Хориотой бэлдмэлүүдийн мөн чанар, бүрэлдэхүүн, хориотой аргуудын мөн чанар, үйлдлийг мэдэхгүй байх нь түгээх болон түгээхийг оролдсон шийтгэлээс ангижруулахгүй.

IX. Хослуулсан шийтгэл ба нөхцлүүд

Тухайн хугацааны турш тамирчны ердийн болон мэдэгдээгүй шинжилгээнээс хамаарч энэхүү дүрэмд заагдсан шийтгэлүүдийг хослон оноож болно.

X. Гишүүдийн авах арга хэмжээ

Тамирчин хүн допингийн нэг зөрчилдөө нэг л удаа шийтгэгдэнэ. Хэрвээ МБСХ тамирчинд энэхүү дүрэмд заагдсан шийтгэлийг оноосон бол Гишүүд түүнд шийтгэл ноогдуулах ёсгүй.

XI. Эмнэлгийн чөлөөлөлт

Тамирчин Анти-допингийн төлөөлөгчөөс энэхүү дүрэмд энгийнээр хориглосон бэлдмэлүүдийг хэрэглэхийг зөвшөөрөхийг хүсэх эрхтэй. Иймэрхүү чөлөөлөлтийг эмнэлгийн хойшлуулшгүй, зайлшгүй баримттай тохиолдолд өгнө.

6-р зүйл. Эерэг шинжилгээний үеийн журам

I. Тэмцээнээс хасах

1. Тамирчны “А” шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд Анти-допингийн төлөөлөгч тэмцээний ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл тухайн тамирчныг нэн даруй тэмцээнээс гаргана.

2. Тамирчны “В” шинжилгээний хариу сөрөг гарвал Анти-допингийн төлөөлөгч тэмцээнээс хассаныг цуцална.
3. “А” ба “В” шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд Анти-допингийн төлөөлөгч нь МБСХ-ны Анти-допингийн сахилгын хороонд тухайн тамирчны нэр, харилцах мэдээлэл, шинжилгээний нөхцөл байдлыг бичгээр мэдээлэх ба мөн хуулбар хийж тухайн тамирчны харъяалагдах МБСХ-ны гишүүн холбоо, клубт мэдээлнэ.

II. МБСХ-ны Анти-допингийн сахилгын хороо

1. МБСХ-ны Анти-допингийн сахилгын хороо (Сахилгын хороо) нь МБСХ-ны бие даасан нэгж болно. Тэрээр дөрвөн гишүүнтэй бөгөөд хоёр нь дараах шаардлагыг хангасан байна:

а) Сахилгын хороогоор хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн боловсролын курсыг амжилттай төгссөн;

б) Монгол улсын хуулийн мэргэжилтний лиценз* эзэмшсэн эсвэл хамгийн бага нь арван жилээр лиценжсэн;

2. Сахилгын хорооны бие даасан байдлыг батлах зорилгоор түүний гишүүд нь МБСХ-ны Тэргүүлэгч эсвэл МБСХ-ны Удирдах хорооны гишүүн бус байна.

3. Анти-допингийн төлөөлөгчийн сахилгын хэрэг явдал үүсгэх үед Сахилгын хороо нь гурван гишүүнээсээ бүрдэх Танхимд хэрэг явдлыг авч хэлэлцэх, шийдвэрлэх даалгавар өгнө. Сахилгын хорооны танхимын дарга нь дээр дурьдсан хуулийн мэргэжлийн хүн байна.

Тайлбар: Энэхүү лиценз нь доод тал нь таван жил байх ёстой.

III. Сахилгын хорооны журам

1. Сахилгын хорооны танхим нь энэхүү Дүрэмд нийцсэн хэрэг явдлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Сахилгын хорооны танхим нь энэхүү Дүрмийн 5-р зүйлд заагдсан зөрчлүүдийг авч хэлэлцэнэ. Хэрвээ тамирчны эсрэг энэ хэргийг үл хэрэгсэм гэж үзвэл журмын хугацааны турш тухайн тамирчныг тэмцээнээс хассаныг хүчингүй болгох эсвэл өөрчилж болно.

3. Сахилгын хорооны танхим нь тусгаарлагдсан өрөөнд уулзана.

4. Сахилгын хорооны танхим хэргийг шийдвэрлэнэ. Шинжилгээний эерэг хариу нь хэргийн субъект болсон тамирчны урьдчилсан бичгэн зөвшөөрлөөр хэргийг байцаалтгүйгээр шийдвэрлэж болно.

5. Хэрэгт холбогдсон хүн өөрийн хэргийг бичгээр болон амаар илтгэх боломжоор хангагдсан байх ёстой. Тэрээр өмгөөлөгч авч болно.

6. Хэрвээ аливаа тамирчин байцаалт авахгүйгээр шийдвэрлэхийг зөвшөөрөхгүй бол Сахилгын хорооны танхим байцаалт авах цаг, газрыг тогтооно. Хэрэгт холбогдсон хүнд байцаалт өгөх хугацааны тухай түүнээс доод тал нь хоёр долоо хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байх ёстой. Сахилгын хороо энэхүү мэдэгдлийн утгыг шийдвэрлэнэ.

7. Тамирчин өөрийнхөө хэргийн байцаалтан дээр ирэхгүй байх, ирэхийг хүлээн зөвшөөрөхгүй байх, Сахилгын хорооны бичгэн мэдэгдлийг үл ойшоох тохиолдолд Сахилгын хорооны танхим байцаалт авалгүйгээр өөрийн шийдвэрийг гаргана.

8. Энэхүү Дүрмийн эсрэг аливаа хуулийн зүйл байж болох боловч Сахилгын хорооны танхим МБСХ-ны ДҮРЭМ, спортын зарчим эсвэл тамирчны эрхэд туслах зорилгоор яаралтай шийдвэр гаргаж болно. Яаралтай шийдвэрийн талаарх гомдол, санал хүсэлтээ Танхимд нэг долоо хоногийн дотор бичгээр гаргаж өгнө. Сахилгын хорооны танхим гомдлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

9. Сахилгын хорооны танхим олонхийн саналаар шийдвэр гаргана.

10. Сахилгын хорооны танхим өөрийн шийдвэрийг бичгээр гаргах ба бүх гишүүд гарын үсэг зурна. Шийдвэр бүр учир шалтгааныг агуулсан байна, санал зөрсөн шалтгаанууд бичигдэхгүй.

IV. Хянан шийдвэрлэхэд оролцуулахгүй байх үндэслэлүүд

1. Дараах тохиолдлуудад Сахилгын хорооны танхимын гишүүн хянан шийдвэрлэхэд оролцохгүй:

а) Сахилгын хорооны гишүүн өөрөө эсвэл түүний үндэсний холбооны тамирчин тухайн хэрэгт холбогдсон,

б) Хэрэгт холбогдсон хүн:

ba) Сахилгын хорооны гишүүний сүйт залуу/сүйт бүсгүй,

bb) Гишүүнтэй гэр бүлийн харьцаатай эсвэл гэр бүлийн харьцаатай байсан,

bc) Гишүүний ойрын хамаатан эсвэл үеэл.

2. Сахилгын хорооны гишүүн урьдчилсан таамгийнхаа талаар өөрөө мэдэгдэж эсвэл Сахилгын хорооны бусад гишүүдэд бичгээр өгнө. Сахилгын хорооны аливаа гишүүн иймэрхүү маргаантай асуудлын талаар мэдмэгцээ мэдээлэх үүрэгтэй. Сахилгын хорооны дарга зөвтгөх шалтгааныг шийдвэрлэнэ.

3. Сахилгын хорооны нэг эсвэл түүнээс олон гишүүн 6-р зүйлийн 4-ийн 1 эсвэл 2-ийн дагуу хянан шийдвэрлэхэд оролцохгүй бол мөн тооны гишүүдийг Тэргүүлэгчдээс нэр дэвшүүлнэ.

V. Зардал

1. Сахилгын хорооны танхим хэргийг хянан шийдвэрлэхэд гарах зардлын эх үүсвэрийн талаар шийдвэр гаргана.

2. Хэрвээ тамирчныг буруутай гэж нотолбол хэргийг хянан шийдвэрлэсэн зардлыг тамирчин хариуцна. Хэрвээ тамирчин Танхимын шийдвэр гарснаас хойш нэг сарын хугацаанд зардлыг төлөхийг хүлээн зөвшөөрөхгүй, ойшоохгүй бол тухайн тамирчныг бүртгэсэн эсвэл гишүүнчилсэн ОУБСХ-ны гишүүн холбоо Танхимын шийдвэр гарснаас хойш хоёр сарын дотор зардлыг төлөх үүрэгтэй. Бусад тохиолдолд ОУБСХ зардлыг хариуцна.

3. Төлөх зардал нь дараах болно:

а) Мэдүүлэг өгөх хүмүүсийг дуудах болон баталгаа гаргуулах

б) Сахилгын хорооны танхимын гишүүдийн унаа, байр, хоолны зардал. Гуравдагч этгээдийн зардлыг даахгүй.

VI. Давж заалдах эрх

Сахилгын хорооны эсвэл түүний аль нэг танхимын гаргасан аливаа шийдвэрт гомдолтой бол Швейцарын Луйзанна дахь Спортын арбитрын шүүхэд түүний дүрэм журмын дагуу давж заалдаж болно. Спортын арбитрын шүүхийн шаардлагын дагуу ийм шийдвэр гарснаас хойш хорин нэгэн хоногийн дотор давж заалдаж болно.

VII. Хүчин төгөлдөр болох нь

Энэхүү Анти-допингийн дүрэм нь МБСХ-ны Тэргүүлэгчдийн 2004 оны 10-р сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрээр батлагдсан ба шууд хүчин төгөлдөр болно.